



Нью Проспект Аудит

Нягтлан болох бүртгэл, аудит, татвар, зөвлөх үйлчилгээ

2021 оны 03 дугаар сарын 01 өдөр

№ 1/04

Улаанбаатар хот

Хараат бус аудиторын дүгнэлт

“Хөвсгөл Усан Зам” ХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Хязгаарлалттай дүгнэлт

Бид “Хөвсгөл Усан Зам” ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайландауд аудит хийллэ.

Бидний дүгнэлтээр, Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн нөлөөллөөс үүсч болзошгүй үр дагавраас бусад зүйлсийн хувьд санхүүгийн тайлан нь “Хөвсгөл Усан Зам” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

“Хөвсгөл Усан Зам” ХК нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангаа тасралтгүй үйл ажиллагааны зарчимд үндэслэн бэлтгэсэн. Компани нь тайлант жил болон өмнөх жилүүдэд алдагдалтай ажилласан ба улс оронд үүссэн нөхцөл байдлын улмаас компанийн эрхэлж буй аялал жуулчлалын үйл ажиллагаа багассан, санхүүгийн болон бусад серег хандлагууд оршсоор байгаа нь компанийн цаашидын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ төрүүлэхүйц материаллаг тодорхой бус байдлыг үүсгэж байна.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн ба эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага” хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бусаар зохион байгуулсан бөгөөд Монгол Улсын хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой асуудлуудыг бид өөрсдийн мэргэжлийн үнэлээмжийг ашиглан аудитын гол асуудалд оруулсан. Бид санхүүгийн тайлангийн дүгнэлтийн хэлбэрийг сонгоходоо эдгээр асуудалд анхаарсан ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй.

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороолол,
Бага тойруу гудамж, Жи Би Центр 701 тоот

Утас: (+976)-70000309
И-мэйл: D.Enebish@newprospect.mn



ATA1037 5891221



Хараат бус аудиторын тайлан (үргэлжлэл)

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайландаа орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайландаа өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээлэлтэй уншиж танилцан, уг мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм. Жилийн тайлантай танилцах үед бусад мэдээлэлд материаллаг алдаа байна гэж үзвэл энэ талаар бид компанийн удирдлагад мэдэгдэх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, эсвэл залтъяа ажиллагааны улмаас материаллаг буруу илэрхийлэгдэгүй санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахад шаардлагатай дотоод хяналтыг зохион байгуулах нь мөн энэхүү хариуцлагад хамаарна.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжийг үнэлж, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлыг санхүүгийн тайландаа тодруулах ба компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоо болон эдгээрээс өөр сонголтгүй болсноос бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлд тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурин санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг компанийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа, залтъяа ажиллагаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад оршино. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь алдаа, эсвэл залилангийн улмаас үүсч болох ба хэрэв дангаараа, эсвэл нийтдээ санхүүгийн тайландаа үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нелөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.





Хараат бус аудиторын тайлан (үргэлжлэл)

Бусад зүйлс

Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудитыг Лайн Аудит ХХК гүйцэтгэж, 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр стандарт дүгнэлт өгсөн бөгөөд бид 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлангийн зэрэгцүүлэх мэдээллийг уг аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэсэн болно.

Энэхүү хараат бус аудиторын дүгнэлт гаргасан аудитын гэрээт ажлын партнер нь Д.Энэбиш болно.



Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланда тусгаагүй болохыг анхаарна уу.

